



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 10 дугаар сарын 29 өдөр Дугаар 89

Хэрлэн сум

LXXXIX ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 89 дүгээр хуралдаан 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 15:00 цагт танхимаар 90,5 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Улсын Онцгой комиссоос аймгийн Онцгой комисст ирүүлсэн албан бичиг танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

2.Коронавируст халдвар /Ковид-19/-ын нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлын талаар мэдээлэл танилцуулах,

Аймгийн ерөнхий тархвар судлаач

3.Эрүүл мэндийн байгууллагуудын эм, эмнэлгийн хэрэгсэл, дархлаа дэмжих бэлдмэлийн нөөц, нас баралтын шалтгаан нөхцөлийн талаар танилцуулах,

Эрүүл мэндийн газар

4.Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангахад тулгамдаж буй асуудлын талаар мэдээлэл танилцуулах,

Аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбат

5.Уул уурхайн компанийн ажилчдыг ээлж солиход зөвхөн "Ковид-19"-өөр өвчилж эдгэрсэн ажилчдаар ээлж солих шаардлага тавьж байгаа талаар мэдээлэл

Мэргэжлийн хяналтын газар

6.Малын өвчний нөхцөл байдлын талаар мэдээлэл танилцуулах,

Мал эмнэлгийн газар

7.Хилийн бүсэд цурав тавих үйл ажиллагаа болон ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдлын талаар мэдээлэл танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

8.Аж ахуй нэгж байгууллагуудад тооллого явуулах тухай санал танилцуулах,

Статистикийн хэлтэс

9.Хэрлэн сумын 11 багийн Засаг дарга, иргэдийн нийтийн хурлын даргыг сонгох хуралдааныг зохион байгуулах талаар санал танилцуулах,

Хэрлэн сумын Засаг дарга О.Пүрэв-Очир

/ М.Бадамсүрэн

/х/а Г.Нармандах

10.Ашиглалтын гэрээгээр ашиглаж байгаа Hi-lux автомашины засвар үйлчилгээний 3,0 сая төгрөгийн зардлыг шийдвэрлүүлэх талаар санал танилцуулах

Тагнуулын газрын дарга, хурандаа Б.Бямбаа

11.Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлт танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын гишүүн Ш.Ёл,
АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,
Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн захирал,
Онцгой комиссын гишүүн Д.Должин нарт:



1.1.Хөгжимт драмын театрт байрлах дархлаажуулалтын цэг, Биеийн тамир спортын газрын спорт зааланд байрлах түргэвчилсэн шинжилгээний цэгүүдийг өөр байршилд шилжүүлж ажиллах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүнд.Мөнхтуяа,
Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Мөнхтөр нарт:

1.2.Аж ахуй нэгж байгууллагатай аймгийн Онцгой комиссоос байгуулсан "Хариуцлагын гэрээ"-ний хүрээнд авч хэрэгжүүлсэн ажлын биелэлтийг нэгтгэж аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүнд.Мөнхтуяа нарт:

1.3.Улсын Онцгой комиссоос аймгийн Онцгой комисст ирүүлсэн 2021 оны 1432 дугаар албан бичгийн дагуу аж ахуй нэгж байгууллагуудтай байгуулах хариуцлагын гэрээний төслийг шинэчлэн боловсруулж аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулах,

 / М.Бадамсүрэн
 /х/а Г.Нармандах

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

1.4.Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлын нөхцөл байдал хүнд байгаа тул урлаг, соёлын салбарын үйл ажиллагааг зохион байгуулахгүй байх талаар Хөгжимт драмын театр, Биеийн тамир, спортын газар, Бөхийн өргөө, Политехникийн коллеж, Хүний хөгжлийн ордон, сумын Соёлын төвүүдэд албан бичгээр чиглэл хүргүүлэх,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн захирал,
Онцгой комиссын гишүүн Д.Должин,
Эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга Д.Оюунтунгалаг,
Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн Эмчилгээ эрхэлсэн дэд захирал Ж.Энхчимэг,
Аймгийн ерөнхий тархвар судлаач, Онцгой комиссын гишүүн Б.Ганганцэцэг нарт:

1.5.Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлаар нас баралт гаргахгүй байх, хүндрэлээс урьдчилан сэргийлэх, ойрын хавьталыг тодорхойлох ажлын төлөвлөгөөг боловсруулж аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулж батлуулах, Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газруудаас дэмжлэг үзүүлж ажиллах,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн захирал,
Онцгой комиссын гишүүн Д.Должин нарт:


1.6.Орон нутгийн хөгжлийн сангаас хөрөнгийг шийдвэрлэсэн антиботик эмийн нөөц бүрдүүлэх худалдан авалтын ажлыг шуурхай зохион байгуулах,

Хоёр.АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,
Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ,
сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

2.1.Аймгийн Засаг дарга сумдад ажиллахтай холбогдуулан сумын Онцгой комисс, мэргэжлийн байгууллагуудын бэлтгэл бэлэн байдлыг хангуулах, мэдээллийг бэлтгэх,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа-д:

2.2.Нийгмийн эрүүл мэндийн төвийн барилгын ажлыг явцын талаар мэдээллийг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад танилцуулах,

 / М.Бадамсүрэн
/х/а Г.Нармандах

Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн захирал,
Онцгой комиссын гишүүн Д.Должин-д:

2.3.Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлын үед дайчлан ажиллаж буй Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын спорт заалыг халдварын нөхцөл бууруулах хэвийн горимд шилжүүлэх,

Гурав.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүнД.Мөнхтуяа-д:

3.1.Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахалд өртөж эдгэрсэн ажилчдын эмчийн магадлагаа, өвчлөөгүй иргэдийн ПГУ шинжилгээний хариуг үндэслэн иргэний эрхийг хүндэтгэж ажлын байранд тусгаарлалтын дэглэмийг баримталж ажиллах талаар Уул уурхайн компани болон туслан гүйцэтгэгч компаниудад албан бичиг хүргүүлж хэрэгжилтийн тайланг нэгтгэж аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулах,

Дөрөв.Аймгийн Статистикийн хэлтсийн
дарга Д.Энхбаатар-д:

4.1.Аж ахуй нэгж, байгууллагын 2021 оны тооллогын ажлыг халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж зохион байгуулах,

Тав.Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Аюушмаа-д:

5.1.Үхрийн арьс товруутах өвчнөөр өвчилсөн үхрийг устгах ажлыг сумдад зохион байгуулах ажлын хэсэг, зохион байгуулах ажлын удирдамжийг аймгийн Онцгой комиссын тогтоол гаргаж баталгаажуулах,


Зургаа.Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын
орлогч дарга Ч.Ганбат,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах нарт:

6.1.Монгол Улсын хил дагуу харлуулсан цурав татах талаар судалж 2022 оны аймгийн төлөвлөгөөнд тусгах, шаардагдах зардлыг аймгийн 2022 оны төсөвт тусгах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Баян-Уул, Баяндун, Дашбалбар, Чулуунхороот
сумын Засаг дарга нарт:

6.2.Монгол Улсын хил дагуу бүс нутгийн сумын Засаг дарга нартай хамтран ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хөдөлгөөнт эргүүлийг томилж ажиллуулахыг тус тус үүрэг болгов.

ДАРГА  М.БАДАМСҮРЭН
ОРЛОГЧ ДАРГА,

ХУРАНДАА  Г.НАРМАНДАХ

